

**ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, ЭРСДЭЛИЙГ
БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨЛТ
DISASTER RISK ASSESSMENT AND RISK
REDUCTION PLANNING**

Ч.Энхболд

ДХИС-ийн магистрант, ахлах дэслэгч

Хураангуй:

Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийг бууруулах төлөвлөлтөд Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл болон сумын Засаг даргын хамтын ажиллагааны хүрээнд тухайн орон нутагт гарч болох эрсдэлийг бууруулж иргэд амар тайван амьдрахад чиглэсэн оновчтой төлөвлөлтийг хийх арга хэмжээний тухайд.

Abstract:

Disaster risk assessment and risk reduction planning: Within the framework of the joint local disaster risk reduction council and the soum governor, measures are taken reduce risk locality and to carry out rational planning aimed at ensuring that citizens live peacefully.

Түлхүүр үг: Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийг бууруулах төлөвлөлтийн хэрэгжилт, төлөвлөгөөний хэрэгжилт, гамшгийн эрсдэлийг бууруулах сан

Keywords: Disaster risk assessment, risk reduction planning implementation, plan implementation, disaster risk reduction fund

Үндсэн хэсэг

Нэг.Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийг бууруулах төлөвлөлт хийхэд нөлөөлж хүндрэл учруулж байгаа хүчин зүйлс

Ховд аймгийн хэмжээнд сүүлийн 5 жилийн байдлаар 2019-2024 онд нийт 506 удаагийн гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсоноос: Объектын гал түймэр-242, хээрийн түймэр-24, хүчтэй салхи шуурга-20, зуд-3, газар хөдлөлт-11, эрэн хайх, аврах ажиллагаа-39, гол, нуурын усанд унаж осолдсон-23, зам тээврийн осол-11, үер, усны дуудлага-44, аяганы мэдээлэл-2, малын гоц халдварт өвчин-72, хүний гоц халдварт /Ковид-19/ өвчин-17 суманд тус тус бүртгэгдсэн байна. Дээрх аюулт үзэгдэл, ослын улмаас 81 хүн амь нас алаж, 20889 толгой мал хорогдсон, 78 гэр, өвөл зуны сууц өртөж, ой, хээрийн түймэрт 45 га талбай өртөж, Онцгой байдлын газрын алба хаагчид 851 хүний амь нас, 21.1 тэрбум төгрөгний хохирол учирсан, 12.28 тэрбум төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан байна.

Хөгжлийн төлөвлөгөө, хөгжлийн үйл ажиллагаанд гамшгийн эрсдэлийг бууруулах бодлого, саналыг тусгаж аюул үзэгдэл, техникийн холбогдолтой осолд холбогдох гамшгийн үр нөлөөг багасгахын тулд удирдлагын шийдвэр, байгууллага, бодлого стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чадвар, нийгэм олон нийтийн тэмцэх чадамж сул байна.

Монгол Улсын гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгад “Төрийн болон нутгийн захиргааны байгууллага тухайн жилд батлагдсан төсвийн 1.0 хувийг, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнд төлөвлөж зарцуулах, аймаг, нийслэл, сум дүүрэг нь тухайн жилийн батлагдсан төсвийн 1.0 хувийг орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах санд тусгаж, гамшгаас хамгаалах арга хэмжээнд зарцуулна” гэж заасан боловч хуулийн хэрэгжилт хангалтгүй улмаас “Гамшгийн эрсдэлийг бууруулах сан” байгуулагдаагүй ба гамшгийн эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийг бууруулах төлөвлөлт хийхэд хүндрэл учруулж байна.

Хоёр: Гамшгийн эрсдэлийн үнэлгээ эрхзүйн орчин

Гамшгийн эрсдэлийн үнэлгээ нь гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах, сэргээн босгох үйл ажиллагаанд чухал үүрэгтэй. Тэгвэл “гамшиг” гэж “аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол”-ийг хэлнэ. “Аюулт үзэгдэл” гэснийг “хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, нуранги, хөрсний гулгалт үүсэх, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, цар тахал, хортон шавж, мэрэгч тархах” гэж Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуульд тодорхойлжээ. Гамшгийн эрсдэл, эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийг бууруулах гээд олон төрлийн ойлголтууд гарч ирнэ.

Монгол улсын хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах эрх зүйн орчин Монгол Улсын үндсэн хууль, амшгаас хамгаалах тухай хууль (2017, шинэчилсэн найруулга), Байгаль орчны тухай хууль, Барилгын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулиудаас бүрддэг байна. Болзошгүй хохирлын хэмжээг багасгах, гамшгийг хохирол багатай даван туулах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг “гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа” гэж нэрлэдэг байна.

Гамшгаас хамгаалах тухай хуульд “төрийн болон нутгийн захиргааны байгууллага,

хуулийн этгээд гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй” байна гэж заасан байдаг бөгөөд уг төлөвлөгөөг урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийн зохион байгуулах удирдлагийн баримт бичиг байна гэж заасан байдаг.

Эрсдэлийн үнэлгээний аргачлал

Гамшгийн эрсдэлийн үнэлгээ нь тодорхой бүс нутаг, салбар, байгууллагад учирч болзошгүй аюул, эрсдэлийг тодорхойлж, түүний магадлал, нөлөөллийг үнэлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг боловсруулах үйл явц юм.

Үнэлгээний шалгуур:

Өндөр – Жил бүр тохиолдох магадлалтай.

Дунд – 10-20 жилд нэг удаа тохиолдож болзошгүй.

Бага – 50-аас дээш жилийн давтамжтай гамшиг тохиолдох давтамж, магадлалыг үнэлнэ.

Дотоод нөхцөл байдлыг тодорхойлоход дараах ойлголтууд хамаарна:

- нөөц болон мэдлэгээр илэрхийлэгдэх байгууллагын чадавх;
- мэдээллийн урсгал ба шийдвэр гаргах үйл явц;
- дотоод оролцогч талууд;
- зорилтууд, түүнд хүрэх стратеги;

Үнэлгээний үр дүнг дараах шийдвэрүүдийг гаргахад хэрэглэнэ:

- үйл ажиллагааг хэрэгжүүлэх эсэх;
- боломжийг хэрхэн хамгийн дээд хэмжээнд хүргэх;
- эрсдэлийн арга хэмжээ авах эсэх;
- төрөл бүрийн эрсдэлийн хувилбаруудаас сонгох;
- эрсдэлийн арга хэмжээний хувилбарыг ач холбогдлоор нь эрэмбэлэх;
- эрсдэлийн арга хэмжээний стратегийн хамгийн тохиромжтой сонголт нь

хүлцэх төвшинд сөрөг эрсдэл дагуулах эсэх.

Нөлөөллийн үнэлгээ

Гамшиг тохиолдвол учрах хохирол, нөлөөллийн түвшинг тооцно.

Нөлөөллийг дараах 4 түвшинд ангилна:

Маш өндөр нөлөөлөл – Амь нас, эд хөрөнгөд ноцтой хохирол учруулна (жишээ нь: газар хөдлөлт 7+ балл).

Өндөр нөлөөлөл – Хүн ам, эдийн засагт томоохон сөрөг үр дагавартай (хүчтэй үер, ой хээрийн түймэр).


Дунд нөлөөлөл – Хэсэг газарт хохирол учруулах боловч нийт системд ноцтой нөлөө үзүүлэхгүй.

Бага нөлөөлөл – Хурдан сэргээн засварлах боломжтой, бага хохиролтой.

Эрсдэлийг бууруулах арга хэмжээ боловсруулах

1. Байгалийн гамшгийн эсрэг хамгаалалт:
 - Усны далан, үерийн хамгаалалт
 - Барилгын газар хөдлөлтийн тэсвэрлэх чадварыг сайжруулах
2. Техноген ослын эсрэг арга хэмжээ:
 - Аж үйлдвэрийн стандарт, хяналтыг сайжруулах
 - Эрсдэлийн менежментэд ISO стандарт нэвтрүүлэх
3. Олон нийтийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх:
 - Иргэдийн сургалт, дадлага зохион байгуулах
 - Гамшгаас хамгаалах сайн дурын бүлэг байгуулах эрсдэлийг багасгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Хяналт ба мониторинг :



Эрсдэлийн үнэлгээ Хяналт ба мониторинг Нөхцөл байдлыг тодорхойлох Мэдээлэх ба зөвлөлдөх Эрсдэлийг илрүүлэх Эрсдэлийг шинжлэх Эрсдэлийг дүгнэх Эрсдэлийн арга хэмжээ Эрсдэлийн менежментийн үйл явц дахь эрсдэлийн үнэлгээний оролцоо Эрсдэлийн шалтгаан, үр дагавар өргөн цар хүрээтэй байх тул эрсдэлийн үнэлгээнд олон төрлийн арга шаардлагатай.

Эрсдэлийн үнэлгээний ангилал

1. Эрсдэлийн үнэлгээг ерөнхий болон нарийвчилсан гэж ангилна.
 2. Эрсдэлийн үнэлгээг энэ журмын 1.3-т заасан түвшинд 3 жил тутам, эсхүл нөхцөл байдлаас хамааран тухай бүр хийнэ.
 3. Эрсдэлийн үнэлгээ нь гамшгаас хамгаалах төлөвлөгөөний үндэслэл болно.
- Гурав. Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ
- 3.1. Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ (цаашид "ерөнхий үнэлгээ" гэх)-г гамшгийн эрсдэлийг тойм, суурь судалгаа байдлаар тодорхойлох зорилгоор хийнэ.
 - 3.2. Ерөнхий үнэлгээг дараахь этгээд гүйцэтгэнэ:
 - 3.2.1. улсын болон стратегийн онц чухал объектын түвшинд онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний томилсноор онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, холбогдох салбарын мэргэжилтэн, эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн ажлын хэсэг;
 - 3.2.2. засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд тухайн шатны Засаг даргын томилсноор төрийн байгууллага болон нутгийн захиргааны байгууллагын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг;
 - 3.2.3. салбарын түвшинд тухайн салбарын удирдлагын томилсноор гамшгаас хамгаалах улсын алба, тухайн салбарын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг.
 - 3.3. Онцгой байдлын байгууллага ерөнхий үнэлгээ хийх үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.
 - 3.4. Ерөнхий үнэлгээний үр дүнд үндэслэн нарийвчилсан үнэлгээ хийлгэж болно.

Гуравт. Эрсдэлийг бууруулах төлөвлөлт

Төлөвлөгөө болосвруулах ажлыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлыг хэсэг хийж гүйцэтгэнэ. Ажлын хэсэгт Онцгой байдлын байгууллага, Засаг даргын тамгын газар төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлэх алба, мэргэжлийн анги хуулийн этгээд, сайн дурынхан, иргэдийн төлөөлөл оролцоно. Онцгой байдлын байгууллага нь төлөвлөгөө боловсруулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, төлөвлөгөөг тухайн орон нутгийн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээн дээр тулгуурлан боловсруулна гэж заасан байдаг.

Үүссэн нөхцөл байдал, үйл явдлыг зангидах, зөв оновчтой зохион байгуулах, хамгийн бага зардал, богино хугацаанд даван туулах хамтын ажиллагааг “гамшгийн эрсдэлийн удирдлага” гэж ойлгож болно. Улс, аймаг, сум, дүүрэг, аж ахуй нэгж байгууллагууд туахын нутаг дэвсгэр болон аж ахуй нэгж байгууллага дээр хийгдсэн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээн дээр үндэслэн

эрсдэлийг бууруулах төлөвлөлт болон төлөвлгөөг боловсруул эрсдэлийг бууруулах анхан шатны арга хэмжээг авч эхэлнэ.

ДҮГНЭЛТ

Гамшгаас хамгаалах хууль эрх зүйн хүрээнд гамшгийн үеийн удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, байгууллага, албан тушаалтны гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх сургалт, дадлага явуулахын зэрэгцээ эрсдэлийн үнэлгээ хийж аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах ажлын төлөвлөж сургах.

Гамшгийн эрсдэлийн санжүүжилт, сэргээн босголтын нөөц хөрөнгийг Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд аймаг, нийслэл, сум, дүүрэг, төрийн байгууллага тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүйг зарцуулахаар тооцон төсөвт тусгах гэж заасан боловч бодит амьдрал дээр энэхүү заалт нь хэрэгждэггүй байна.

САНАЛ

Эрсдэлийг бууруулах санг аймаг, аж ахуй нэгж байгууллага дээр тусд нь сан бий болгох ажлыг сангийн яамтай хамтран ажиллах.

Төрийн болон аж ахуй нэгж байгууллага дээр нэгдсэн нэг үнэлгээний заавар, аргачлалын хүрээнд зохион байгуулдаг болгох.

Аймаг, сум, аж ахуй нэгж байгууллага дээр гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийдэг мэргэжлийн нэг алба хаагчийг сургаж орон тоог гаргаж ажиллах. “Онцгой байдлын байгууллагаас гадна”.

Ашигласан эх сурвалж:

1. Архангай аймгийн сүүлийн 5 жилийн “Гамшиг ослын тоон” мэдээлэл
2. “Гамшгаас хамгаалах тухай хууль-шинэчлэн найруулсан ” 2017 он
3. “Гамшиг судлалын хүрээлэн”- “Гамшгийн нэр томъёоны тайлбар толь” 2012 он
4. “Гамшгийн төрөл бүрээр эрсдэлийн үнэлгээ хийх арга зүй” 2016 он
5. “Гамшгийн эрсдэлийн удирдлагын чадавхыг бэхжүүлэх зөвлөмж” 2020 он
6. “Гамшгийн эрсдэлийн удирдлагын эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл” 2020 он
7. “Монгол Улсын Шадар сайдын 68 дугаар тушаал” 2021 он